

## ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

### 2016 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ТАЙЛАН

2016.06.17

Улаанбаатар хот

#### Өргөдөл, гомдлын мэдээ

Тайлант хугацаанд байгууллагын ажилчдаас болон иргэдээс нийт 18 өргөдлийг бичгээр хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэн, хариу өгч ажилласан байна.

Бичгээр гаргасан өргөдлийн агуулгыг тоймлон үзвэл байгууллагын ажилчдаас ирсэн чөлөө, буцалтгүй тусламж хүсэх тухай, иргэдээс Худалдан авах үйл ажиллагаатай холбогдолтой асуудлаар ирүүлсэн өргөдөл дийлэнх хувийг эзэлж үнэлгээний хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлөгдөх тухай хүсэлт тодорхой хувийг эзэлж байна.

*Ирсэн өргөдөл, гомдлын агуулга, бүтцийн судалгаа*

*Огноо: 2016/01/01-2016/06/18*

Д/д	Агуулга	Бичгээр	Цахим	Нийт	Нийт өргөдөлтэй харьцуулсан
1.	Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлөгдөх тухай хүсэлт	2	-	2	11,1%
2.	Ажилд орох, ажлаас чөлөөлөгдөх, шилжин ажиллах тухай хүсэлт	3	-	3	16,5%
3.	Чөлөө, буцалтгүй тусламж хүсэх тухай	7		7	38,8%
4.	Худалдан авах үйл ажиллагаатай холбогдолтой асуудлаар	6	-	6	33,3%
5.	Нийт	18	-	18	100 %


#### **2.Засгийн газрын “11-11” төвд худалдан авах ажиллагаатай холбогдож ирсэн санал, хүсэлтийн мэдээ**

Засгийн газрын иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах “11-11” төвөөс 2016 оны хагас жилийн байдлаар худалдан авах ажиллагаатай холбогдсон асуудлаар 11 санал шүүмжлэлийг хүлээн авч тухай бүр хариу өгч хамтран ажилласан байна. Иргэдээс ирсэн санал, гомдол, хүсэлтийг төрлөөр нь ангилж үзвэл санал-6, гомдол-3, шүүмжлэл-1, талархал-1 ирүүлсэн, 10 санал хүсэлтийг дуудлагаар, 1 саналыг вэб сайтаар ирүүлсэн байна.

*Ирүүлсэн санал, шүүмжлэл, гомдлыг харьяалагдах байгууллагаар нь авч үзвэл:*

- ✓ Сангийн яаманд хамаарагдах асуудлаар-2 санал,
- ✓ Худалдан авах ажиллагааны газартай холбогдолтой асуудлаар-5,
- ✓ Орон нутгийн Худалдан авах ажиллагааны албатай холбогдолтой асуудлаар-2 санал тус бүр ирүүлсэн байна.
- ✓ Худалдан авах ажиллагааны үйл ажиллагаатай холбогдолгүй асуудлаар-2 санал тус бүрийг ирүүлсэн байна.

“11-11” төвд худалдан авах ажиллагаатай холбогдсон асуудлаар ирсэн мэдээг өнгөрсөн 2 жилийн байдалтай харьцуулвал:



ЗГ-ын иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах “11-11” төвөөр дамжуулан иргэдээс худалдан авах үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлт өнгөрсөн 2 жилийн мөн үетэй харьцуулахад 15 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь

- Иргэдийн худалдан авах ажиллагааны чиглэлийн мэдлэг, мэдээлэл дээшилсэн,
- Мөн мэргэжлийн байгууллагын зүгээс иргэд, олон нийтэд мэдээллийг цаг алдалгүй хүргэж байгаатай холбоотой гэж дүгнэж байна.

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТЭС